

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/235/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn

Аудитор: Э.Цэлмэгбаяр
Утас: 260512 Цахим хаяг: tseimegbayare@audit.gov.mn

Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал:
Г.Мөнхбаяр
Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН
САНГИЙН ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/406
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 704 дүгээр тогтоолоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын улсын 2024 оны хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон Үндэсний номын сангийн шинэ барилга, дулааны шугам сүлжээ, цахилгааны дэд бүтцийн хөрөнгийг 22,799,278.7 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Соёлын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлүүлж,

160,031.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авахаас 67,774.1 мянган төгрөгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Монгол Улсын Үндэсний Номын сан нь бичиг соёлын өв, оюуны үнэт бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж хойч үедээ үлдээх үүргийн хүрээнд Монгол бичгийн өв, Гэр үеийн бичмэл буюу угийн бичиг, Цогт хунтайжийн санаашрал баримтат киноны үзэсгэлэн, Академич Бямбын Ринчений мэндэлсний 120 жил, С.Дашдооров судлал эрдэм шинжилгээний хурлыг тус тус зохион байгуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,468,253,137.61	1,115,518,460.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	209,600.09	423,600.09
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	209,600.00	423,600.00
31110	Төгрөг	209,600.00	423,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.09	0.09
3121	Төгрөг	0.09	0.09
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	0.09	0.09
33	АВЛАГА	35,768,759.06	129,148,764.59
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	863,182.50	2,556,466.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,400,000.00	12,874,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	32,998,846.14	111,120,901.67
335	Бусад авлага	506,730.42	2,597,396.42
33510	Байгууллагаас авах авлага	156,540.00	1,539,206.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	350,190.42	1,058,190.42
34	УРЬДЧИЛГАА	4,608,200.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	4,608,200.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,427,666,578.46	985,946,095.74
351	Түүхий эд материал	23,435,000.00	22,415,000.00
35110	Тусгай зориулалттай материал	23,435,000.00	22,415,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	89,957,698.00	89,550,450.00
354	Хангамжийн материал	1,314,273,880.46	873,980,645.74
35410	Бичиг хэргийн материал	82,468,280.00	7,444,405.00
35420	Аж ахуйн материал	10,854,669.00	8,666,305.00
35430	Сэлбэг хэрэгсэл	81,982,999.56	56,546,099.56
35440	Түлш, шатах тослох материал	5,808,000.00	700,000.00
35450	Барилгын засварын материал	1,663,000.00	844,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,131,496,931.90	799,779,836.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,884,994,359.14	34,673,113,851.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,884,994,359.14	34,673,113,851.24
392	Биет хөрөнгө	11,878,833,324.20	33,404,407,949.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,316,283,636.00	24,115,562,319.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(790,376,669.92)	(920,937,298.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,020,000.00	69,020,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.00)	(12,835,833.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,055,991,081.13	6,090,830,256.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,321,268,078.77)	(2,301,802,795.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,108,252,435.00	2,110,042,435.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(236,452,212.44)	(475,751,273.19)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,756,872,000.00	2,756,872,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	266,585,411.50	281,675,411.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(55,994,844.85)	(105,617,537.69)
39217	Ном	1,710,770,566.55	1,797,350,266.35
393	Биет бус хөрөнгө	1,006,161,034.94	1,268,705,901.25
39301	Программ хангамж	614,597,900.00	622,597,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(142,374,100.06)	(231,310,716.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	594,408,100.00	993,708,843.00

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39304	Хуримтлагдсан элэгдэл	(60,470,865.00)	(116,290,125.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>14,353,247,496.75</u>	<u>35,778,632,311.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>29,640,144.63</u>	<u>62,053,090.92</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>29,640,144.63</u>	<u>62,053,090.92</u>
413	Өглөг	<u>29,640,144.63</u>	<u>62,053,090.92</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,028,871.11	3,828,537.92
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,977.00	-
4136	Бусад өглөг	<u>20,608,296.52</u>	<u>58,224,553.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	18,867,882.43	28,469,292.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,740,414.09	29,755,261.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>14,323,607,352.12</u>	<u>35,726,579,220.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>14,323,607,352.12</u>	<u>35,726,579,220.74</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,834,267,039.88	1,834,267,039.88
51101	Өмч: - төрийн	1,834,267,039.88	1,834,267,039.88
512	Хуримтлагдсан үр дүн	<u>8,381,700,104.65</u>	<u>29,784,671,973.27</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	8,348,029,528.49	8,381,019,739.36
51220	Тайлант үеийн үр дүн	33,670,576.16	21,403,652,233.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,107,640,207.59	4,107,640,207.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>14,353,247,496.75</u>	<u>35,788,632,311.66</u>

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,017,461,222.98	28,272,763,062.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,759,290,150.00	28,272,763,062.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,759,290,150.00	23,622,077,027.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,759,290,150.00	322,240,230.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	322,240,230.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,759,290,150.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	23,286,436,420.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	13,400,377.00
122	Тусламжийн орлого	-	4,650,686,034.53
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,650,686,034.53
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,306,631,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,306,631,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	344,054,934.53
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	344,054,934.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,258,171,072.98	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,638,067,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,638,067,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	620,103,372.98	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	385,368,832.98	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,834,540.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,767,945,746.82	6,872,565,828.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,767,945,746.82	6,872,565,828.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,647,783,039.58	6,665,858,301.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,144,991,182.00	3,634,802,122.00
210101	Үндсэн цалин	2,048,681,847.00	2,238,906,795.00
210102	Нэмэгдэл	389,362,165.00	400,897,517.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	420,649,000.00	701,368,250.00
210104	Урамшуулал	286,298,170.00	293,629,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	393,461,977.19	454,005,218.83
210201	Тэтгэврийн даатгал	271,185,437.09	312,113,206.59
210202	Тэтгэмжийн даатгал	31,222,049.32	36,623,328.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,517,718.62	19,254,917.88

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	13,842,936.24	16,333,535.88
210205	Эрүүл мэндийн даатгал	60,693,835.92	69,680,230.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,864,472.43	217,213,475.89
210301	Гэрэл, цахилгаан	57,458,395.81	108,603,896.28
210302	Түлш, халаалт	53,204,197.01	91,296,136.75
210303	Цэвэр, бохир ус	10,201,879.61	17,313,442.86
2104	Хангамж, бараа материалын зардал	226,376,225.42	644,939,092.98
210401	Бичиг хэрэг	32,685,638.00	213,942,547.00
210402	Тээвэр, шатахуун	9,732,000.00	4,898,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,003,424.32	39,035,514.26
210404	Ном, хэвлэл	26,461,360.00	40,453,349.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,885,340.00	14,068,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	109,608,463.10	332,540,932.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,836,000.00	21,967,696.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	783,640.00
210604	Урсгал засвар	28,836,000.00	21,184,056.00
2107	Томилолт, зочны зардал	47,552,000.00	-
210702	Дотоод албан томилолт	47,552,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	238,821,972.00	125,633,351.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	231,121,202.00	117,929,944.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,250,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,493,800.00	3,325,000.00
210807	Газрын төлбөр	956,970.00	4,192,407.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	186,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,446,879,210.54	1,567,297,344.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,739,858.00	3,515,346.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,289,040.00	7,023,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,413,850,312.54	1,556,758,808.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,162,707.24	206,707,526.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	68,909,552.86
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	68,909,552.86
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	68,909,552.86
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	6,162,554.58
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	62,746,998.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,668,954.66	137,797,973.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,700,000.00	18,319,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,118,354.66	119,478,973.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,850,600.00	-

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,493,752.58	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,248,514.95	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,245,237.63	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	249,515,476.16	21,400,197,233.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,167,500.00	3,455,000.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,167,500.00	3,455,000.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	218,012,400.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	218,012,400.00	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(215,844,900.00)	3,455,000.00
7	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,670,576.16	21,403,652,233.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,564,279,812.45	4,997,906,110.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,997,906,110.67
122	Тусламжийн орлого	-	4,997,906,110.67
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,997,906,110.67
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,306,631,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	4,306,631,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	691,275,010.67
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	377,053,780.67
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	314,221,230.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,564,279,812.45	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,638,067,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,638,067,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	926,212,112.45	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	390,590,072.45	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	362,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	172,722,040.00	-

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,406,840,298.61</u>	<u>4,939,475,230.67</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,406,840,298.61	4,939,475,230.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,256,685,145.23	4,651,129,029.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,146,245,408.69	3,639,802,376.10
210101	Үндсэн цалин	2,064,251,956.69	2,125,401,379.10
210102	Нэмэгдэл	389,403,208.00	542,613,364.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	421,001,225.00	701,076,814.00
210104	Урамшуулал	271,589,019.00	270,710,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,914,456.22	460,357,464.30
210201	Тэтгэврийн даатгал	289,457,838.12	332,372,989.93
210202	Тэтгэмжийн даатгал	27,563,995.82	32,863,826.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,809,973.87	16,541,276.88
210204	Ажилгүйдлийн даатгал	12,910,164.99	15,610,459.38
210205	Эрүүл мэндийн даатгал	53,172,483.42	62,968,911.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,032,400.00	226,752,938.32
210301	Гэрэл, цахилгаан	55,864,335.50	109,701,857.84
210302	Түлш, халаалт	45,007,684.89	99,832,547.62
210303	Цэвэр, бохир ус	10,160,379.61	17,218,532.86
2104	Хангамж, бараа материалын зардал	151,993,260.32	64,685,117.26
210401	Бичиг хэрэг	30,675,880.00	7,398,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,849,732.32	33,066,565.26
210404	Ном, хэвлэл	24,048,500.00	280,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,885,340.00	1,954,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,533,808.00	21,986,152.00
2105	Нормативт зардал	10,065,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,065,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,160,550.00	61,575,166.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,986,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,090,450.00	470,000.00
210604	Урсгал засвар	41,070,100.00	52,118,466.00
2107	Томилолт, зочны зардал	46,063,600.00	-
210702	Дотоод албан томилолт	46,063,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307,410,553.00	164,674,077.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	291,622,743.00	160,531,242.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	604,150.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,474,800.00	825,000.00
210807	Газрын төлбөр	2,008,860.00	1,992,235.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,700,000.00	1,325,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,799,917.00	33,281,890.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	24,020,200.00

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,799,917.00	9,261,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,155,153.38	288,346,201.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	180,030,454.53
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	180,030,454.53
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	180,030,454.53
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	6,162,554.58
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	62,746,998.28
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	111,120,901.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,662,554.66	108,315,746.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,993,600.00	8,888,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,118,354.66	99,427,746.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,550,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,492,598.72	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,248,514.95	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	36,244,083.77	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>157,439,513.84</u>	<u>58,430,880.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	157,297,013.75	58,216,880.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,297,013.75	58,216,880.00
2200	Дотоод эх үүсвэрээр	157,297,013.75	58,216,880.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	157,297,013.75	58,216,880.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(157,297,013.75)</u>	<u>(58,216,880.00)</u>
250005	Төлсөн ногдол ашиг	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	142,500.09	214,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,100.00	209,600.09
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	209,600.09	423,600.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,267,039.88	4,107,640,207.59	8,348,029,528.49	14,289,936,775.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,834,267,039.88	4,107,640,207.59	8,348,029,528.49	14,289,936,775.96
Тайлант үеийн үр дүн	-	-	33,670,576.16	33,670,576.16
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,267,039.88	4,107,640,207.59	8,381,700,104.65	14,323,607,352.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(680,365.29)	(680,365.29)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,834,267,039.88	4,107,640,207.59	8,381,019,739.36	14,322,926,986.83
Тайлант үеийн үр дүн	-	-	21,403,652,233.91	21,403,652,233.91
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,267,039.88	4,107,640,207.59	29,784,671,973.27	35,726,579,220.74

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
12	Татварын бус орлого	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
122	Тусламжийн орлого	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
122005	Төсвөөс санхүүжих	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,470,473,000.00	4,300,468,545.42	170,004,454.58	96.2
210	Бараа, үйлчилгээний зардал	4,347,033,800.00	4,201,040,798.72	145,993,001.28	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,409,632,500.00	3,366,651,707.10	42,980,792.90	98.7
210101	Үндсэн цалин	1,861,487,800.00	1,852,250,710.10	9,237,089.90	99.5
210102	Нэмэгдэл	716,868,500.00	542,613,364.00	174,255,136.00	75.7
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	566,313,800.00	701,076,814.00	(134,763,014.00)	123.8
210104	Урамшуулал	264,962,400.00	270,710,819.00	(5,748,419.00)	102.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	426,204,100.00	426,204,099.30	0.70	100.0
210201	Тэтгэврийн даатгал	298,459,300.00	298,219,624.93	239,675.07	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	31,936,200.00	32,863,826.35	(927,626.35)	102.9
210203	ҮОМШӨ ний даатгал	15,968,100.00	16,541,276.88	(573,176.88)	103.6
210204	Ажилгүйдлийн даатгал	15,968,100.00	15,610,459.38	357,640.62	97.8
210205	Эрүүл мэндийн даатгал	63,872,400.00	62,968,911.76	903,488.24	98.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,215,400.00	226,752,938.32	17,462,461.68	92.8
210301	Гэрэл цахилгаан	116,910,900.00	109,701,857.84	7,209,042.16	93.8
210302	Түлш, халаалт	99,250,700.00	99,832,547.62	(581,847.62)	100.6
210303	Цэвэр, бохир ус	28,053,800.00	17,218,532.86	10,835,267.14	61.4
2104	Хангамж, бараа материалын зардал	42,430,800.00	37,733,640.00	4,697,160.00	88.9
210401	Бичиг хэрэг	3,290,100.00	2,700,550.00	589,550.00	82.1
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	19,752,200.00	18,052,910.00	1,699,290.00	91.4
210404	Ном, хэвлэл	9,368,000.00	9,368,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,362,600.00	1,954,250.00	2,408,350.00	44.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	5,657,900.00	5,657,930.00	(30.00)	100.0
2106	Эд хогшил худалдан авах	64,482,400.00	470,000.00	64,012,400.00	0.7

**Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	64,012,400.00	-	64,012,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	470,000.00	470,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	111,567,800.00	99,307,734.00	12,260,066.00	89.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,049,700.00	95,164,899.00	4,884,801.00	95.1
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,977,100.00	-	4,977,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,164,700.00	-	1,164,700.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	1,496,900.00	825,000.00	671,900.00	55.1
210807	Газрын төлбөр	1,998,100.00	1,992,235.00	5,865.00	99.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,881,300.00	1,325,600.00	555,700.00	70.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,500,800.00	43,920,680.00	4,580,120.00	90.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,009,300.00	43,429,180.00	4,580,120.00	90.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	491,500.00	491,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,439,200.00	99,427,746.70	24,011,453.30	80.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,439,200.00	99,427,746.70	24,011,453.30	80.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,004,700.00	-	24,004,700.00	-
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,434,500.00	99,427,746.70	6,753.30	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	209,600.09	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	209,600.09	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	112	102	10	91.1
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	61	58	3	95.1
620003	Үйлчлэх ажилтан	50	43	7	86.0

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	691,275,010.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	691,275,010.67
122	Тусламжийн орлого	691,275,010.67
1221	Хандив тусламж /дотоод/	691,275,010.67
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	691,275,010.67
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	377,053,780.67
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	314,221,230.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	517,193,110.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,193,110.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,305,110.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,150,669.00
210101	Үндсэн цалин	273,150,669.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,153,365.00
210201	Тэтгэврийн даатгал	34,153,365.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,977,477.26
210401	Бичиг хэрэг	4,697,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,013,655.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,266,222.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,027,066.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,483,600.00
210604	Урсгал засвар	58,543,466.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,426,343.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,426,343.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,570,190.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,770,190.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,888,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,888,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,888,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	174,081,899.95
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(174,081,899.95)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(174,081,899.95)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Үндэсний Номын сан нь эрхэм зорилгоо “Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, хэрэглэгч төвтэй үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж, цахим номын сангийн жишиг үйлчилгээ нэвтрүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндэсний Номын сан нь Монголын ард түмний бичиг үсгийн дурсгал болох соёлын баримтат өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, ном хэвлэлийг сурталчлах, үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг зохион байгуулах, бусад номын санг эрдэм шинжилгээ судалгаа, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах болон ном уншлагын танхим, цахим үйлчилгээ үзүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхий тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Соёлын сайдын баталсан номын сангийн үйл ажиллагааны холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тушаал “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”
- Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 дугаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тус номын сан нь дотоод аудитын нэгж, ажилтангүй. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар дотоод аудитыг хийдэг бөгөөд тайлант хугацаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Үндэсний Номын сан нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,435,384.8 мянган төгрөгөөр буюу 149.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	209.6	423.6	214.0
Авлага	35,768.7	129,148.7	93,380.0
Урьдчилгаа	4,608.2	-	(4,608.2)
Бараа материал	1,427,666.6	985,946.1	(441,720.5)
Үндсэн хөрөнгө	12,884,994.4	34,673,113.9	21,788,119.5
Нийт хөрөнгийн дүн	14,353,247.5	35,788,632.3	21,435,384.8
Өр төлбөр	29,640.1	62,053.1	32,413.0
Засгийн газрын хувь оролцоо	14,323,607.4	35,726,579.2	21,402,971.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,353,247.5	35,788,632.3	21,435,384.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Авлага дансны үлдэгдэл нь 129,148.7 мянган төгрөг болж 93,380.0 мянган төгрөгөөр өссөн нь түрээсийн болон бусад авлагын үлдэгдэл 12,874.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 111,120.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан;
- Урьдчилгаа данс 4,608.2 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй гарсан нь Үндэсний номын сангийн шинэ барилга ашиглалтад орохтой холбогдуулан гарсан тохижилтын ажлын зардлыг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл нь 985,946.1 мянган төгрөг болж 441,720.5 мянган төгрөгөөр буурсан нь 140,028.9 мянган төгрөгийн материалыг худалдаж авч, 7,845.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн болон тусгай зориулалтын материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 593,169.7 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, 1,980.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүний данснаас хассан зэргээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 34,673,113.9 мянган төгрөг болж 21,788,119.5 мянган төгрөгөөр өссөн нь 58,216.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 704 дүгээр тогтоолыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Үндэсний номын сангийн барилга, гадна тохижилт, зам талбай, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийг 23,061,312.8 мянган төгрөгөөр бүртгэж, тайлант хугацаанд 1,556,758.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 62,053.1 мянган төгрөг болж 32,413.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны эцсээр төрийн сангаас гүйлгээ хийх эрхийг хаасантай холбоотойгоор хувь хүний орлогын албан татварын өглөг 3,719.0 мянган төгрөг, бараа, үйлчилгээний худалдан авалтын 58,224.5 мянган төгрөгийг өр төлбөрийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалсан;
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл нь 35,726,579.2 мянган төгрөг болж, 21,402,971.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,149,330.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,224,841.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 396,668.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 276,663.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 648,878.2 мянган төгрөгөөр, нормативт зардал, томилолт, эд хогшил, урсгал засварын зардлыг

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

561,51.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 549,968.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 361,701.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 3,935,904.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 534,568.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,470,473.0 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 4,306,631.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 4,300,468.5 мянган төгрөгийг зарцуулж, 6,162.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,300,468.5 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлыг 72,070.8 мянган төгрөгөөр, харуул, хамгаалалтын зардлыг 4,884.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс хуваарилсан зардлыг 93,042.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71702	Соёл урлаг	4,470,473.0	4,300,468.5	170,004.5	96.2
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,197,007.8	4,124,937.0	72,070.8	98.3
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны аж	1,600.0	1,600.0	-	100.0
80219	Харуул, хамгаалалтын зардал	8,802.1	3,917.4	4,884.7	44.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	99,434.5	99,427.7	6.8	100.0
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	3,597.6	3,597.6	-	100.0
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	160,031.0	66,988.8	93,042.2	41.9

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Биет бус хөрөнгө: Номын сангийн үйл ажиллагаатай холбоотой 618,890.4 мянган төгрөгийн өртөгтэй 4 программ хангамж, Санхүүгийн тооцоолох групп ХХК-аас худалдан авсан “Accolus” санхүүгийн программ, түүний нэмэлт модуль 3,707.5 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Унаа хоол: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 61 дүгээр зүйлийн 61.1.10 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 8.4 дэх заалт, Хамтын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Захирлын 2025 оны А/41 тоот тушаалаар 30.0 мянган төгрөгийг 50 хувиар бууруулж 15.0 мянган төгрөгөөр тооцож шинэчлэн тогтоосон байна. Тайлант хугацаанд хоол унааны зардалд 566,313.8 мянган төгрөг төсөвлөж, 701,472.0 мянган төгрөгийг зарцуулж, 134,763.0 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

Сургалт: Сургалт, семинар, хурал зөвлөгөөний 18 арга хэмжээг зохион байгуулахаар 8,770.0 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 28 арга хэмжээг 9,261.7 мянган төгрөгөөр зохион байгуулсан байна.

Бүтэц орон тоо: Номын сангийн бүтэц орон тоог 112 хүнээр анх баталсан боловч төсвийн тодотголоор 102 болж буурсан байна. Гүйцэтгэлээр 105 орон тоотой ажиллаж гүйцэтгэх албан тушаалын 3, үйлчилгээний албан тушаалын 5 хүнээр цомхотгосон байна.

Аудитаар дээрх зардлуудтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 377,053.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 314,221.2 мянган төгрөг, нийт 691,275.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 307,304.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 127,574.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 73,426.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 8,888.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 173,867.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Улсын Үндэсний Номын сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Азуре хүлүг аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Бямбасүрэн, туслах аудитор Л.Болор-Эрдэнэ, Г.Баасанбат нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Цэлмэгбаяр, аудитын менежер И.Эрдэнцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,767,945.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 57,679.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын Үндэсний Номын сангийн орон тооны бус Мэргэжлийн зөвлөл, Эрдмийн зөвлөл, Ёс зүйн дэд хороо, Залуучуудын зөвлөлд хороодод ажилласан урамшуулал олгоогүй, 2025 оны 10 дугаар сараас эхлэн ажилтны ур чадварын нэмэгдэл, хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдэл олгоогүй, хоол, унааны хөнгөлөлтийг хамтын гэрээнд өөрчлөлт оруулан 50 хувиар бууруулах арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 29 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 5,299,531.4 мянган төгрөгийн 59 ажил гүйлгээ, 29 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны II улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 107,312.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 681.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах 31,506.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	681.2	1	681.2	100.0
Албан шаардлага	2	31,506.3	2	31,506.3	100.0
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	6	32,187.5	6	32,187.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын шинэчлэлийг санхүүгийн программдаа тусгасан эсэх;
- Монгол Улсын Үндэсний Номын санд хэрэгжиж буй Азийн сонгодог бүтээлийг цахимжуулах төслийн хэрэгжилтийн гүйцэтгэл, үр дүнд горим сорил гүйцэтгэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 221,538.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд хандив тусламжаар хүлээн авсан 219,383.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад хэсэгт тайлагнасан;
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 175.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авснаар бүртгэж ангилал буруу тайлагнасан;
- Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний компанид төлөх 1,980.0 мянган төгрөгийн хог тээврийн үйлчилгээний төлбөрийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсан.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, тооцооллын алдаа стандартын 42-т “...Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухай санхүүгийн тайлан гарахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг” гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 50,480.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 2,348.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтож, 48,131.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 50,480.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 7,199.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн тооцоололд ажилласан цагийг илүү бүртгэж 1,973.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цагийн бүртгэлийг буруу хөтөлж 1,973.3 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон;

2. Төсвийн хөрөнгөөр 375.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1-д "төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон;

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны эцэст түрээсийн төлбөрийн авлагын үлдэгдэл нь 9,570.0 мянган төгрөгөөр өсөж, авлага барагдуулах ажил хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн авлагыг барагдуулаагүй, авлагын үлдэгдэлтэй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн;

2. Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий 38,561.7 мянган төгрөгийн бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийдэггүй, жагсаалтыг хүргүүлдэггүй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн;

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд хандиваар хүлээн авсан 219,383.5 мянган төгрөгийн хөрөнгийг бусад хэсэгт бүртгэсэн байна.	1	219,383.5	-	-	1	219,383.5	1	219,383.5	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 175.0 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авснаар бүртгэсэн байна.	1	175.0	-	-	1	175.0	1	175.0	-	-	-	-
Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний компанид төлөх хог тээврийн үйлчилгээний төлбөр 1,980.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй байна.	1	1,980.0	1	1,980.0	-	-	1	1,980.0	-	-	-	-
Дүн	3	221,538.5	1	1,980.0	2	219,558.5	3	221,538.5	-	-	-	-

Монгол Улсын Үндэсний Номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацааны эцэст түрээсийн төлбөрийн авлагын үлдэгдэл нь 9,570.0 мянган төгрөгөөр өсч, авлага барагдуулах ажил хангалтгүй байна.	1	9,570.0	-	-	1	9,570.0	-	-	-	-	-	-
Цалингийн тооцоололд ажилласан цагийг илүү бүртгэж 1,973.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.	1	1,973.3	1	1,973.3	-	-	-	-	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр 375.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	375.0	1	375.0	-	-	-	-	-	-	-	-
Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий 38,561.7 мянган төгрөгийн бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.	1	38,561.7	-	-	1	38,561.7	-	-	-	-	-	-
Дүн	4	50,480.0	2	2,348.3	2	48,131.7	-	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 31/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/235/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 375,000.00 (гурван зуун далан таван мянга) төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д "энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 375,000.00 (гурван зуун далан таван мянган) төгрөгийг шийдвэр гаргасан Монголын үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоогоор төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын үндэсний номын сангийн ахлах нягтлан бодогч (Э.Энхзул)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 32/АД150122

Улаанбаатар хот

САГ - 2026/235/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцоололд ажилласан цагийг илүү бүртгэж 1,973,300.00 (нэг сая есөн зуун далан гурван мянга гурван зуун) төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон цалин 1,973,300.00(нэг сая есөн зуун далан гурван мянга гурван зуу) төгрөгийг цалингийн тооцоолол хийсэн нягтлан бодогч Ш.Бота, хянасан ахлах нягтлан бодогч Э.Энхзул нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын үндэсний номын сангийн захирал (Б.Ичинхорлоо)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225_SAG-23.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 207/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/235/НА -СТА -ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.


Тайлант хугацааны эцэст түрээсийн төлбөрийн авлагын үлдэгдэл нь 9,570,000.00 (есөн сая таван зуун далан мянган) төгрөгөөр өсөж, авлага барагдуулах талаар хэрэгжүүлсэн ажил хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн авлагыг барагдуулаагүй, авлагын үлдэгдэлтэй гарсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний номын сангийн захирал (Б.Ичинхорлоо), ахлах нягтлан бодогч (Э.Энхзул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 208/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/235/НА-СГА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний номын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий 38,561,756.00 (гучин найман сая таван зуун жаран нэгэн мянга долоон зуун тавин зургаан) төгрөгийн бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийдэггүй, жагсаалтыг хүргүүлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний номын сангийн захирал (Б.Ичинхорлоо), ахлах нягтлан бодогч (Э.Энхзул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shoardlaga\2026\0125 SAG-30.Docx

1526180551